

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2010 он 01 дүгээр
сарын 27 -ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Азийн Хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, уг төслийн дагуу батлагдах журмуудын төсөл, тэдгээртэй холбоотой ажлын явцын байдлын ерөнхий танилцуулгыг Үнэт цаасны газрын дарга Э.Ганбат, Азийн Хөгжлийн Банкны олон улсын хуулийн зөвлөх Малколм Гоулд нар хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай болон Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, уг төслийн дагуу батлагдан мөрдөгдөх журмуудын төсөл, тэдгээртэй холбоотой ажлын явцын байдлын ерөнхий танилцуулгыг сонсоод Азийн хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд хэрэгжиж буй төслийн ажил цаг үеэ олсон, үр дүнтэй ажил болж буйг тэмдэглэн төсөл амжилттай хэрэгжиж байна гэж дүгнэв.

2. Төслийн хүрээнд олон улсын хуулийн зөвлөх Малколм Гоулд өндөр идэвхи санаачлагатай ажилласан болохыг сайшаан тэмдэглэв.

3. Хүчин төгөлдөр үйлчилж буй Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийн хүрээнд батлагдах боломжтой журмуудыг 2010 оны эхний улиралд багтаан хэлэлцүүлж батлуулахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т үүрэг болгохоор тогтов.

4. Хөрөнгийн зах зээлийн бодлогын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн ажиллагааг нь тогтмолжуулах, холбогдох хууль болон журмуудын төслийг олон нийтэд суртачлан таниулах арга хэмжээг зохион байгуулахыг Хөрөнгийн зах зээлийн бодлогын зөвлөлийн дарга, Хорооны байнгын гишүүн Д.Дүгэржавд үүрэг болгохоор тогтов.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН